



ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМ

БОДИТ МЭДЭЭЛЭЛ ИРГЭНИЙ ОРОЛЦОО



2022 он

ГАРЧИГ

ӨЛЗИЙТ СУМЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН УТАСНЫ ЖАГСААЛТ.....	4
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ	6
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ	9
БАЙГАЛЬ ОРЧИН	23
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ.....	27
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ.....	38
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД.....	44
ГАЗРЫН ХАРИЛЦАА	49
“МАЛЧИН ДААТГУУЛАГЧ”-ААР ТЭТГЭВЭР ТОГТООЛГОЖ МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЖ БАЙГАА ИРГЭДИЙН АНХААРАЛД .	57
ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ.....	64
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:.....	66
СОЁЛЫН ТӨВ	71
ӨЛЗИЙТ СУМЫН МАЛЧДЫН МАЛЫН ИМ, ТАМГАНЫ ЖАГСААЛТ	77

ӨМНӨТГӨЛ

ӨЛЗИЙТ СУМЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН УТАСНЫ ЖАГСААЛТ

д/д	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Д.Жаргалсайхан	ИТХ-ын дарга	88096893
2	Ж.Наранжав	ИТХ-ын Нарийн бичгийн дарга	88714040
3	Б.Гасрандорж	Засаг дарга	88088270
4	Х.Шинэбаатар	Засаг даргын орлогч	86077990
5	Б.Оюунханд	ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч	88402208
6	Б.Болдбаатар	Санхүүгийн албаны дарга	88010372
7	О.Балсан	Мал эмнэлгийн тархвар зүйч	88307983
8	Н.Отгонсүрэн	Хүнс, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн	88854241
9	М.Ганчимэг	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	80013811
10	Б.Будгэрэл	ЗДТГ-ын нягтлан бодогч	88047200
11	Т.Одонтунгалаг	Тусгай сангууд болон соёлын төв хариуцсан ня-бо	80084105
12	Э.Сайхантуяа	Боловсрол хариуцсан нягтлан бодогч	80922949
13	Б.Мөнхцэцэг	1-р багийн Засаг дарга	88705502
14	П.Алтанцэцэг	2-р багийн Засаг дарга	88596515
15	М.Айлтгүй	3-р багийн Засаг дарга	88117980
16	П.Нямхүү	4-р багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч	95702435
17	Т.Дунгаамаа	5-р багийн Засаг дарга	88046075
18	Ө.Буд-Очир	6-р багийн Засаг дарга	88784520
19	Б.Наранцэцэг	ЗДТГазрын нярав	88303021
20	Х.Гантөмөр	Жижүүр	89707430
21	А.Түмэндэмбэрэл	Архив, бичиг хэргийн эрхлэгч	88707702
22	О.Баттогтох	ЗДТГ-ын жолооч	89929000
23	Х.Энэбиш	Цагдаагийн хэсгийн мөрдөгч	88332332

24	Ц.Дашням	Хэсгийн цагдаа	88160189
25	Г.Уранчимэг	Нийгмийн даатгалын байцаагч	88707065
26	Н.Жадамба	Газрны даамал	98233044
27	У.Саруул-Эрдэнэ	Хөдөлмөр, эрхлэлт халамжийн асуудал мэргэжилтэн	86635589
28	М.Түмэнбаяр	ШҮЗМонтёр	88007648
29	О.Буяндэлгэр	Цаг уурын харуул	80263979
30	Н.Гомборрагчаа	Байгаль хамгаалагч	93208853
31	Б.Бадрах	Байгаль хамгаалагч	88011451
32	М.Болормаа	ЕБСургуулийн захирал	88303073
33	Б.Мөнхчимэг	Эрүүл мэндийн төвийн дарга	88031604
34	Б.Хорлоо	Цэцэрлэгийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	88929295
35	Ц.Хадхүү	Соёлын төвийн эрхлэгч	88778186
36	Ц.Мөнгөнчимэг	Вакцинатор сувилагч	80993998
37	М.Эрдэнэтуяа	Эм эргэлтийн сангийн эрхлэгч	88092112
38	Эрүүл мэндийн төв	ЭМТөвийн дуудлага хүлээн авах утас	93159531
39	Б.Энхцацрал	“Жирмийн булаг” ХХК-ний ШТГСтанцын түгээгч	86888890
40	Ч.Цэцэг	“Ембүүт булаг” ХХК МЭҮНэгж	88600410
41	Д.Баярсайхан	“Өлзийтийн-Өсөх” ХХК МЭҮНэгж	88184565
42	П.Туяацэцэг	“Бор хацавч” ХХК МЭҮНэгж	88704370
43	Х.Лхагважав	“Дэртийн-Өсөх” ХХК МЭҮНэгж	86040554
44	Э.Хүүхайчин	“Баянхөх-Овоо” ХХК МЭҮНэгж	88990523
45	Б.Отгонтуяа	Хаан банкны эрхлэгч	80047704
46	С.Эрхэм	Төрийн банкны эрхлэгч	88049994
47	Ч.Оюунбаатар	“Ган-Илч” ХХК-ний орон нутаг хариуцсан ажилтан	80400030
48	О.Өлзиймаам	Шуудан үйлчилгээний ажилтан	88507933

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд орсон зарим нэгэн өөрчлөлтөөс дурьвал:

1. Сум өөрийн өмчтэй байна
 - а. Өмчлөгчийн эрхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, өмчийн удирдлагыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон эрхийн хүрээнд сумын Засаг дарга хэрэгжүүлнэ.
2. Сум нь Төсвийн тухай хуулинд зааснаас өөр орон нутгийн сантай байж болно. Уг санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна.
3. Нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд иргэн дараах эрхтэй.
 - а. Иргэн нь шууд болон төлөөллийн байгууллагаараа уламжлан нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй.
 - б. Иргэн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, багийн иргэдийн нийтийн хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл олж авах эрхтэй.
4. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Багийн иргэдийн нийтийн хурал нь Тэргүүлэгч байхгүй болсон бөгөөд Зөвлөлтэй байна. Зөвлөл нь хуралдаанд бэлтгэх, хуралдааны шийдвэрийг сурталчлах, хороодын үйл ажиллагааг уялдуулах үүрэгтэй. Зөвлөл нь шийдвэр гаргах эрхгүй.
5. Багийн иргэдийн нийтийн хурлын дарга гэж байхгүй бөгөөд хуралдааны даргыг Багийн иргэдийн нийтийн

хурлаас сонгоно. Хуралдаан бүр дээр хуралдааны даргыг өөрчилж болох бөгөөд улируулан сонгож болно. Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно.

- a. Эрх үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах хувьдаа ашиглах
 - b. Өөр шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх
6. Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа бол тухайн тойргийн сонгогчдын олонхийн саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна. Эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаан 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

7. Сумын ИТХ-ын хуралдааны дэг баталлаа.
8. ИТХ-ын дэргэд 5 хороо байгуулж “Хороодын үйл ажиллагааны журам”-ыг хэлэлцэж батлав. Үүнд:
 - c. Нутгийн удирдлагын хөгжлийн хороо дарга С.Эрхэм
 - d. Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо дарга Э.Нямхүү
 - e. Нийгэм, дэд бүтэц, цахим бодлогын хөгжлийн хороо дарга Х.Шинэбаатар
 - f. Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хороо дарга С.Даваачимэг
 - g. Ёс зүйн хороо дарга Д.Жаргалсайхан
9. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ёс зүйн дүрэм батлав.
10. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулж, Зөвлөлийн даргаар Д.Жаргалсайхан, гишүүдэд Б.Мөнхцэцэг, Ө.Буд-Очир, Т.Дунгаамаа, Х.Шинэбаатар

нарыг баталлаа.

11. Хоршоо хөгжүүлэх сангийн заал олгох, салбар чиглэл тогтоох, зээлийн төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын Зөвлөл байгуулах, төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай хэлэлцэж шийдвэрлэв.
12. 11 эхийг “Алдарт эхийн” одонгоор шагнуулахаар уламжиллаа.
13. Боловсрол дэмжих сумын хөтөлбөр батлагдлаа.
14. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдөл хэлэлцэж саналаа өглөө.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанд иргэний төлөөлөл Н.Гангамаа, Д.Цэцэгсүрэн нар оролцлоо.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн анхдугаар хурлын Зөвлөлийн хуралдаанаар ИТХ-ын хороодоос 2022 онд хяналт шалгалт хийх удирдамжийг хэлэлцэж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар батлуулан хороодын дарга нарт хүргүүлэв. Мөн “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэж батлуулах талаар сумын Засаг даргад чиглэл өглөө. Энэ оны 1-р улиралд сумын 6 багийн иргэдийн нийтийн хурлаа хийж багийн иргэдийн нийтийн Зөвлөлөө байгуулж, Багийн Засаг даргаа сонгож сумын Засаг даргад томилуулахаар уламжиллаа.

Сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид

Д/д	Багийн нэр	Мандатын тоо	Төлөөлөгчийн нэр
1	Буянт - 1	3	Н.Оргилбаяр М.Адъяа Б.Мөнхцэцэг
2	Буянт - 2	4	Д.Жаргалсайхан Т.Чанцал Э.Сайхантуяа Б.Баярхүү
3	Тагт	2	А.Эрдэнэбат М.Айлтгүй
4	Дэрт - 1	3	Б.Энхбаяр Э.Нямхүү Г.Улаанхүү
5	Дэрт - 2	4	Ч.Цэцэг О.Ган Т.Дунгаамаа Ц.Ганбат С.Эрхэм
6	Рашаант	5	Х.Отгонмөнх Х.Шинэбаатар Ө.Буд-Очир С.Даваачимэг

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ

Мал аж ахуйн салбарын 2021 оны жилийн эцсийн мал тооллогын дүн



Сумын өрх, хүн ам, малчин өрхийн тоон мэдээлэл

№	Баг	Өрхийн тоо	Хүн амын тоо	Малтай өрх	Малчин өрх	Мал бүхий өрх	Мянгат малчдын тоо
1	Буянт-1	128	372	112	107	5	30
2	Буянт-2	183	444	162	157	5	41
3	Тагт	132	321	116	112	4	17
4	Дэрт-1	140	329	118	110	8	14
5	Дэрт-2	191	574	161	146	15	28
6	Рашаант	160	398	40	17	23	0
Дүн		934	2438	709	649	60	130

МАЛ ТӨЛЛӨЛТ: 2022 оны хавар 680 өрхийн 279,3 мянган толгой мал хаваржиж байна. Сумын хэмжээнд 2021 оны жилийн эцсээр 142,1 мянган толгой эх мал тоологдож, 112,7 мянган толгой

эх мал хээлтүүлэгт орсон. Үүнээс: ингэ - 1717, гүү - 446, үнээ - 130, эм хонь - 44517, ишиг - 40517 нийт 87485 төл хүлээн авч төллөлт 77,6 хувь, төл бойжилт 100 хувьтай байна.

ОТОР НҮҮДЭЛ: Гадны 3 аймгийн 6 суманд 8 өрхийн 6859 толгой мал, өөрийн аймгийн 6 суманд 13 өрхийн 6927 толгой мал өвөлжиж хаваржаад байна.

МАА-Н БҮРТГЭЛЖҮҮЛЭЛТ: Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-т заасны дагуу үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгч малыг дахин давтагдашгүй хувийн дугаараар ялган тэмдгэлжүүлж, “Малын бүртгэл мэдээллийн сан”-д оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд 2022 онд хээлтүүлэгч малыг 100% ээмэгжүүлэхээр төлөвлөж байна.

Ноолуурын гарц өндөртэй Дэл уулын улаан ямааны омогийн судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, нэр дэвшүүлж буй малчны ажлын үзүүлэлтийн баталгаажуулалт

/Аймгийн аварга малчин шалгаруулах журам нь 2022 оноос
улсын аварга малчны журамтай ажлын үзүүлэлтүүд нь адил
болсон/

	Дугаар	Журманд заасан шалгуурууд	Шалгуур үзүүлэлтийн нэр	Баталгаажуулалт
1	2.1.1	Мал сүргээ жилийн дөрвөн улиралд уламжлалт аргаар өөрөө малладаг, мал маллагааны туршлагаа залуу малчдад зааж сургаж, шавь малчинтай болсон орон нутагт ажлын байр бий болгож, ядуурлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байх	Малын тоо төрлөөр	Сумын төрийн сангийн төлөөлөгчийн тодорхойлолт / мал тооллогын программаас татсан/
2			Туслах малчны тоо	Туслах малчин тус бүртэй байгуулсан гэрээний хуулбар
3			Туслах малчинд олгосон цалингийн хэмжээ	Банкны гүйлгээний баримт
4			Малжуулах зорилгоор хандивласан малын тоо	Малжуулах зорилгоор олгосон малын төрөл, нас, хүйс, малжуулсан өрхийн жагсаалтыг сүүлийн 3 жилээр гаргасан сумын ЗДТГ-ын даргын тодорхойлолт
5			Ядуурал бууруулах үйлсэд оролцсон бусад үйл ажиллагаа	Тухайн үйл ажиллагааг зохион байгуулагчийн тодорхойлолт, өгөөж хүртэгчийн тодорхойлолт

6	2.1.2	Өөрийн эзэмшлийн өвөлжөө хаваржааны хашаатай	Хашаа, худгийн тоо	Хашааны эзэмшлийн гэрчилгээ, худгийн паспортын хуулбар
7		доройтсон бэлчээрийг сайжруулах худаг гаргах, булаг шандны эхийг хамгаалахад хөрөнгө оруулалт хийсэн байх	Бэлчээрт хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгийн хэмжээ /төг/	Сумын ХААТасгийн тодорхойлолт
8	2.1.3	Сумын тухайн жилийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэх, өнжөөх, отор хийх зэргээр даацыг хэтрүүлэхгүйгээр ашигладаг өвөл хаврын улирлын бэлчээр ашиглах гэрээ байгуулсан, бэлчээрийн хортон мэрэгч, шавжтай тэмцэх зэрэг бэлчээр хамгааллын ажилд оролцдог байх	Өвөлжөө хаваржааны бэлчээрийг ашиглах гэрээ	Гэрээ болон түүний биелэлт
9		Бэлчээр ашиглалт, отор нүүдэл хийсэн тухай мэдээлэл	Сумын ХААТасгийн тодорхойлолт	
10		Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтад, шавьжтай тэмцэх ажилд оролцсон тухай мэдээлэл	Үлийн цагаан оготно, царцаатай тэмцсэн ажилд оролцсон тухай ЗДТГ-тай хийсэн хэлцлийн хуулбар, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт	
11		Бэлчээр ашиглалтын зөрчил гаргаагүй тухай баримт	Сумын Байгаль орчны байцаагчийн тодорхойлолт, сумын Цагдаагийн тодорхойлолт	

12	2.1.4	Жил бүрийн мал өвөлжилт, хаваржилтад бэлтгэх өвс тэжээлийн нийт хэмжээ нь нэг хонин толгойд өндөр уулын бүсэд 20кг, ойт хээрийн бүсэд 50кг, тал хээрийн бүсэд 40кг, говийн бүсэд 5кг-аас багагүй байх	Бэлтгэсэн өвс тэжээлийн хэмжээ кг	Байгалийн хадлан гар тэжээл, ногоон тэжээл хивэгний хэмжээ, бэлтгэсэн байдлын талаар газар дээр нь мэргэжлийн баг ажилласан дүгнэлт тэмдэглэл
13	2.1.5	Тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохирсон төрөл, үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, малын чанарыг сайжруулж, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлсэн байх	Өсгөн үржүүлж буй малын үүлдэр, малын төрөл тус бүрээр	Сумын ХААТасгийн тодорхойлолт
14			Малын чанар сайжруулах, сүргийн зохистой бүтэц бий болгох чиглэлээр хийсэн ажил, санаачлага	Мал үржүүлэг технологийн, нэгжтэй байгуулсан гэрээний хуулбар, сумын ХААТасгийн дэлгэрэнгүй тодорхойлолт
15	2.1.6	Жил бүр үржлийн малдаа үзлэг ангилалтыг технологит хугацаанд хийлгэсэн байх	Үзлэг ангилалтад хамруулсан малын тоо, нийт сүрэгт эзлэх хувь	Сумын ХААТасгаар баталгаажуулсан мал ангилалтын тайлангийн хуулбар тухайн өрхөд хамаарах хэсэг

16	2.1.7	Үржлийн малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, үржлийн малын удам гарвал, ашиг шимийн чиглэл тодорхой байх	Бүртгэлд хамрагдсан малын төрөл, тоо	Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн мэдээлэл, ХААТасгийн тодорхойлолт
17			Удам зүйн үнэлгээнд хамрагдсан малын тоо	Удам зүйн үнэлгээний программд орсон талаарх ХААТасаг, МҮТАҮНэгжийн тодорхойлолт
18	2.1.8	Чанар стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлдэг байх	Ялган төвлөрүүлсэн богийн хээлтүүлэгчийн тоо	Сумын ХААТасгийн тодорхойлолт
19			Удам зүйн үнэлгээнд хамрагдсан хээлтүүлэгчийн тоо	Удам гарвацийн гэрчилгээ, үржилд ашигласан хээлтүүлэгчийн хувийн дугаар, ашиг шимийн чиглэл, үүлдрийн нэр, гэрээ түрээсийн хэлбэрээр ашигласан эсэх талаарх ХААТасаг, МҮТАҮНэгжийн тодорхойлолт

20	2.1.9	Хээлтүүлэгчийн сүрэгт эзлэх хувийн жин бог малд 55, бод малд 40 болон түүнээс дээш хувьд хүрсэн, бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай байх	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан малын тоо	Мал эмнэлгийн гарал үүслийн программаас тодорхойлолтыг гаргасан байх
21			Угаалга, туулгад хамрагдсан малын тоо, төрлөөр	
22	2.1.10	Сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэн сүрэгт эзлэх таваарын малын 40-өөс доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх	Зах зээлд борлуулсан малын тоо	Сумын МЭ-н тасгийн гарал үүслийн гэрчилгээ
23			Үржилд худалдаалсан малын тоо	Сумын ХААТасгийн тодорхойлолт
24	2.1.11	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа тогтмол, бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтөлдөг, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт өвчин гараагүй, малын зүй бус хорогдолгүй байх	Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар	
25			Вакцинд хамрагдсан тухай мэдээлэл	
26			Гоц халдварт болон халдварт өвчний гаралтын мэдээлэл	Сумын МЭТасгийн тодорхойлолт

27	2.1.12	Малчин нь малын тоо толгойн албан татварыг тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон хэмжээгээр бүрэн төлсөн байх	Татварт төлсөн төгрөгийн тоо	Сумын татварын байцаагчийн тодорхойлолт, цахим системийн хуулгын хамт, малын тоо толгойн албан татвар тогтоосон тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хуулбар
28	2.1.13	Малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд даатгуулж, малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан байх	Малчин өрхийн гишүүд нийгмийн даатгалд хамрагдсан байдал	E-Mongolia цахим системийн тодорхойлолт
29			Малчин өрхийн гишүүд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал	E-Mongolia цахим системийн тодорхойлолт
30			Даатгуулсан малын тоо, төрөл	Даатгалын компани байгуулсан гэрээний хуулбар
31			Даатгалын хураамж төлсөн баримт	Гүйлгээ хийсэн банк

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН: Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Сум хөгжүүлэх сан нь 2022 оны 01 дүгээр сараас Хоршоо хөгжүүлэх сан болж өөрчлөгдсөн.



Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам

ЖДҮХариуцсан мэргэжилтэн Н.Отгонсүрэн

1

Хоршоог хөгжүүлэх сан

Сангийн зарцуулалт

- Сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн томолодог тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөл сонгон шалгаруулах төвөг тогтоосно.
- Төсөл хүлээн авах хугацааг хоршоо, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн олонхдоо мэдэгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.
- Тухайн сумын хамгийн олон гишүүтэй, үйл ажиллагааны чиглэл дөвөрдөггүй нэг хоршоог тэргүүн ээлжид дэмжинэ.

5



Зээлийн нөхцөл

- Сангаас хоршоо, жижиг, дунд үйлдвэр олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна.
- зээлийн хүүгийн хэмжээ жилийн 3 хувь;
- зээлийн хугацаа нь 60 хүртэл сар байна.
- зээлийн эргэн төлөлтийн эхний 12 хүртэлх сарын хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлж болно.
- Сангийн зээлийн эргэн төлөлтийн төлбөр нь сар бүр тэнцүү байна.
- Зээлийн хэмжээ 100 хүртэл сая

4

Хоршоог хөгжүүлэх сан

Хоршоодод тавигдах шаардлага

- Тухайн суманд бүртгэлтэй, төлбөртэй үйл ажиллагаа явуулдаг байх;
- Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
- Зээлийн зөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай байрладаг зорилготой байх;
- Хоршоогоос үйл ажиллагаа болон жижиг, дунд үйлдвэр, үйлчлэгээ эрхлэх талаар зохио мэдээг тусгажлалтай байх;
- Хоршоо нь Хоршооны тухай хуульд заасны дагуу хоршооны мөргөлийн холбоонд элсэх тэдэрийлөгт авсан байх;
- 3-аас доошгүй хэвт нэмэлтэй үйл ажиллагаа эрхлэх, санхүүгийн тайлангаар багачаахуулсан байх.

6



Төсөлд тавигдах шаардлага

- Тухайн суманд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх бодлогын гэрээнд эрэн нутгийн нөхцөл шийтгэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, эрэн нутгалт тусламждаг байгаа асуудлыг шийдвэрлэхэд чөлөөтэй байх;
- Төслийн хурж үр дүн, эсрэгт тодорхой байх;
- Гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх;
- Төслийн зээлийн мөнгөн дүнд урьдчилууц, барьцаа хөрөнгөтэй байх;
- Төслийг хэрэгжүүлэх явцад эцэс, бодлошуу арга хэлтэй бодитой тодорхойлох, давхцан туулах арга замыг тусгасан байх;
- Ачлан байр нэмэгдүүлэхэд чөлөөтэй байх;
- Хоршооны гишүүнчлэлийг нэмэгдүүлсэн байх;
- Хоршооны гишүүдийн орлоцог тусгасан байх.

7

Хоршоог хөгжүүлэх сан

ЗЭЭЛ АВАХ ХҮСЛЭТЭЙ ХОРШОО, ИДҮГЭЙН БҮГДЭЭГЭЙ МАТЕРИАЛ:

1. Зээлдэгчийн өнөгт
2. Зээл олгохыг хүссэн өргөдөл
3. Оршин суугаа газрын тодорхойлолт
4. Төслийн баримт бичиг
5. Барьцаа хөрөнгийн үнэмлэхүй жагсаалт /тайлан!
6. Барьцаа хөрөнгийн гэрчилгээ /эх хувиар!
7. ХАА-н хоршоолсгогчдын холбооны гишүүн хоршоогоор элссэн тухай нотлох баримт
8. Хоршоог хөгжүүлэх төлөвлөгөө

8

Хоршооны бүртгэл:



ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ ШИНЭЧЛЭН БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН ХОРШООД ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛДЭЭ ХАМРАГДАНА УУ.

Бүрдүүлэх материал:

1. Хоршооны хурлын тэмдэглэл,
2. Хурлын тогтоол,
3. Хоршооны дүрэм 2 хувь,
4. Татварын тодорхойлолт,
5. 10.000 төгрөг тушаасан баримт,
6. УБ-Змяягт бөглөж тамга дарах,
7. Гэрчилгээ эх хувиар авчрах,
8. Хоршоодын холбооны тодорхойлолт

Харъяа аймаг, сумын Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлнэ үү.

Хүнсний аюулгүй байдал:

НИЙСЭГЛИЙН МЭРГЭЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮНИЙ ЗУРААСАН КОД

865 6020985 01 2

Усний код | Байгууллагын дугаар | Бүтээгдэхүүний дугаар | Хамтлагч үнэм

Зураасан кодны эхлэл:

300-379	Франц	520	Грек	779	Аргентин
380	Болгар	539	Ирланд	780	Чили
383	Словен	540-549	Бельги, Люксембург	789-790	Бразил
400-440	Герман	569	Исланд	800-839	Итали
450-459	Япон	599	Унгар	840-849	Испани
490-499		622	Египет	850	Куба
460-469	ОХУ	629	Эмират	858	Словак
470	Киргистан	570-579	Дани	859	Чех
471	Тайвань	590	Польш	860	Югослав
475	Латви	594	Румын	865	Монгол
477	Литва	599	Унгар	869	Турк
478	Узбекистан	622	Египет	870-879	Нидерланд
479	Шри Ланка	640-649	Финланд	880	Өмнөд Солонгос
480	Филлипин	690-695	Хятад	885	Тайланд
481	Беларус	700-709	Норвеги	888	Сингапур
482	Украин	729	Израил	890	Энэтхэг
484	Молдав	730-739	Швед	893	Вьетнам
485	Армен	750	Мексик	899	Индонез
486	Гүрж	759	Ванесуэл	900-919	Австри
487	Көвчөвстөн	760-769	Швейцари	930-939	Австрали
489	Хон-Конг	775	Перу	940-949	Шинэ Зеланд
500-509	Англы	777	Боливи	955	Малайз

Цэвэрлэлт №2 ОЮУТНУУДАЛ

ХУВАНЦАР САВНЫ ХЭРЭГЛЭЭ БА ЗЭРҮҮЛ МЭНД

Шидэцлэг сангаар, хүнсний зориулалтын бус хуванцар савны хөдөөмөлд хүний эрүүл мэндэд эерэг оролцоо үзүүлж чаддаг бодон агууламдаг. Эргэлтгүй дууны кулцалын үнэмлэхтэй шүүгч, каппер, үргүүдэл, арьсны шөвгөн, хэрчил, идэвхтэй маршалит зэрэг мэргэн шийтгэн болодог.

ОЮУТАН ТА ХЭРЭГЛЭЖ ЗАНШААРАЙ

- Металл эсвэл цахилгаан, хайлцаа
- Зориулалтын усны сав
- Тусгай зориулалтын шөвгөн уут
- Халаагч болон халуун усны хайлцаа өөрчлөх сав

ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОНО

- Болгоон дотооны тусгай зориулалтын бус хуванцар сав хайлцаа
- Хүйтэн усны зориулалтын хайлцаа, халуун ус, эсвэл халаа

Тэмдэглэгээ бүхий хуванцар савыг хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтаар хэрэглэнэ үү

АНХААР!!! Зориулалтын бус сав баглаа боодолд хүнсний үүүхийг эд, бүтээгдэхүүнийг салгахыг хориглоно.

<p>МАЛЧИД ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХАД ШААРДЛАГАТАЙ ӨВС ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ ТУХАЙ</p> <p><u>Бүх малаа хонин толгойд шилжүүлэх заавар:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Тэмээний тоог х 5 2. Адууны тоог х 7 3. Үхэрний тоог х 6 4. Хонины тоог х 1 5. Ямааны тоог х 0.9 тус тус үржүүлж хонин толгойд шилжүүлнэ. Үүний дараа нэг мал тутамд 3кг өвс, 1кг гар тэжээл, 2кг хужир шүү бэлтгэхээр тооцож нийт өвс тэжээлээ бэлтгэнэ. 	<p>УСААР ХАНГАГДСАН ӨРХ ГЭЖ ЮУ ВЭ?</p> <table border="1"> <tr> <td>БОГ МАЛ</td> <td>→</td> <td>3км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.</td> </tr> <tr> <td>ҮХЭР</td> <td>→</td> <td>4км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.</td> </tr> <tr> <td>АДУУ</td> <td>→</td> <td>10км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.</td> </tr> </table> <p>Дээр зааснаас хол усандаа явж уудаг бол усаар хангагдаагүй өрх гэнэ.</p>	БОГ МАЛ	→	3км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.	ҮХЭР	→	4км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.	АДУУ	→	10км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.
БОГ МАЛ	→	3км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.								
ҮХЭР	→	4км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.								
АДУУ	→	10км дотор явж уудаг бол усаар хангагдсан өрх гэнэ.								

Мал эмнэлэгийн тасаг

Малчид болон мал бүхий иргэд та бүхэн мал эмнэлгийн дуудлага үйлчилгээ, зөвлөгөө авах бол хариуцсан багийн малын эмч нартай дараах утсаар холбогдоно уу?

№	МЭҮНэгжийн нэр	Хариуцсан эмч	Хариуцсан багийн нэр	Холбогдох утасны дугаар
1	“Өлзийтийн -Өсөх” ХХК	Д.Баярсайхан	Буянт-2	88096893
2	“Ембүүт булаг” ХХК	Ч.Цэцэг	Дэрт-2	88600410
3	“Бор хацавч” ХХК	С.Хүүхэнбаатар	Буянт-1, Тагт	86704370
4	“Дэртийн -Өсөх” ХХК	Х.Лхагважав	Дэрт-1	88307983
5	“Баян хөх овоо” ХХК	Э.Хүүхайчин	Дэрт-2	98131858 88990523

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж



Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аргууд



Өвчилж тэмдэглэгдсэн малыг тогтоосон хугацаанд нядалгаанд оруулах, малаа бусад айлын малтай ус, бэлчээрээр нийлүүлэнгүй байх, бусад малчинтай хашаа хороо, тоног хэрэгслээ сольж хэрэглэнгүй байх



Ямарваа нэг өвчний шинж тэмдэг илрэх бүрт хариуцсан малын эмч, сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн малын эмчдээ дуудлага өгч, үзлэг хийлгэх, онош тогтоолгох



Мал эмнэлгийн төлөвлөгөөт вакцинжуулалт, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа сайн дураараа, идэвхтэй хамруулах

Малын өвчний мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг чандлан мөрдөх



Зун, намрын улиралд малаа угаалгад бүрэн хамруулах



Яль болох өврийн орон нутагт отор, нүүдэл нийж

Өвөлжөө, каваржаа бууцанд ула-жилаат болон орчин үеийн аргаар ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол нийлгэх



Зайлшгүй тохиолдолд отор, нүүдэл хиймдээ орон нутгийн мал эмнэлгийн байгууллага, малын эмч нараас малын өвчний талаар мэдээлэл, зөвлөгөө авах, оторлож болох бүс нутгийг тодруулах

Шаардлагагүй тохиолдолд өвчний голомттой аймаг, сумдаар зорчигчгүй байн, зайлшгүй шаардлагаар зорчсон бол намгийн багадаа 5 оног мэлдаа ойртонгүй байх



Сүрэг элбэн, малын цус сайжруулан зорилгоор малын сүрэгт нийлүүлэн бол эхлээд тодорхой нугацаанд тусгаарлан ажиллах



Өвчний голомттой болон голомт бүртгэгдсэн бүс, аймаг, сумаас мал худалдан авахгүй байх, мал сүрэгтээ нийлүүлэнгүй байх



Дур мэдэн оношлон, эмчлэхээс зайлснийн



Өвчлөл бүртгэгдсэн бүсээс мал, малын гаралтай бүтээгдэхүүн худалдаж авахгүй, зарахгүй байх



БАЙГАЛЬ ОРЧИН

Дундговь аймгийн Өлзийт сум нь газар нутгийн хэмжээ том ялангуяа алт, хайлуур жонш зэрэг ашигт малтмалын илэрц бүхий газруудад байгаль орчныг ухаж сүйтгэх, газрын хэвлий хөндсөн хэрэг зөрчлүүд нь эрүүгийн гэмт хэрэгт хамаардаг тул малчид, ард иргэд та бүхэн үйлдэх ба эс үйлдэх зөрчлөөс ангид байж өөрийн гэр орон, хороо бууцны орчимд хууль бус, зөрчлийн шинжтэй үйл ажиллагаа илэрсэн тохиолдол бүрт сумын Хэсгийн мөрдөгч, хэсгийн цагдаа, байгаль орчин болон өөрийн Багийн Засаг дарга нарт яаралтай холбогдож мэдээллэж байхыг дахин дахин анхааруулж байна!!!

Зөрчлын тухай хуулиас: Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлүүд бүгд хамаарна. Үүнээс орон нутагт гарч болзошгүй зөрчилд ноогдох торгуулиас түүвэрлэн хүргэж байна.

- ✓ **Амьтан:** Амьтныг ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлийг хураан авч 150.000-1.500.000 төгрөгөөр торгоно
- ✓ **Ургамал:** Ургамалд зөрчил үүсгэсэн бол 100.000-1.000.000 төгрөгөөр торгоно
- ✓ **Говийн заг:** Мод бэлтгэх эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн бол 300.000-3.000.000 төгрөгөөр торгоно
- ✓ **Байгалийн чулуу:** Байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг олборлосон, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, хадгалсан бол 1.000.000-10.000.000 төгрөгөөр тус тус торгууль ногдуулна.
- ❖ Малчид иргэдийн дунд зөвшөөрөлгүй гүний худаг гаргах тохиолдлууд гардаг тул үүнтэй холбоотой зайлшгүй мэдвэл зохих хуулийн заалтуудыг хүргэж байна.

Усны тухай хуулиас:

26 дугаар зүйл. Ус ашиглах зориулалт, төрөл

26.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна.

26.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус ашиглах, хэрэглэх зориулалтаас хамааруулан дараах байдлаар ангилна:

26.2.1. Ус хэрэглэгч; /үүнд иргэд унд ахуйд хэрэглэхийг ойлгоно/

26.2.2. Ус ашиглагч: /үүнд иргэн болон ААН нь үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглахыг ойлгоно/.

27 дугаар зүйлээс: Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл

27.1. Цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах зөвшөөрлийг ус хэрэглээний тоо хэмжээ, чанарыг үндэслэн **Аймаг, нийслэлийн байгаль орчны газар** нь хуулийн дагуу худаг гаргах зөвшөөрлийг олгохдоо дараах материалыг харгалзан үзнэ. Үүнд:

- ✓ Геофизикийн хайгуулын дүгнэлт
- ✓ Уст цэг гаргах аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, Улсын бүртгэлийн гэрчилгээ, холбогдох материалууд
- ✓ Худаг гаргах зөвшөөрлийг 1 өрхөд өгдөггүй тул 1 цэгт худаг гаргах хүсэлтэй байгаа малчдын өргөдөл
- ✓ Иргэний үнэмлэхний хуулбар өрхийн тэргүүн бүр
- ✓ Багийн Засаг даргын тодорхойлолт: Үүнд
 - Тухайн багийн худаг гаргах шаардлагатай байгаа малчдын хүсэлтийн дагуу тухайн байршилд ус гаргах болсон шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарлах
 - Тухайн уст цэгээс хэдэн өрхийн хэдэн толгой мал

/бог, бодоор/ уух тухай ач хобогдолоор нь тус тус үнэн бодит судалгааны үндсэн дээр тодорхойлж бичсэн байна

- ✓ Кадастрын зураг Тухайн худгаас уух ойролцоох малчдын өвөлжөө, хаваржааны газрын байршлын зураг өрх тус бүр
- ✓ Малын А дансны хуулбар /худаг гаргах хүсэлтэй байгаа багын хэсгийн айл тус бүрээр/
- ✓ Бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлнэ.

Малчид, иргэд дур мэдэн зөвшөөрөлгүй гүний худаг гаргах зөрчил гаргадагтай холбогдуулан зайлшгүй мэдвэл зохих холбогдох хуулийн заалтуудыг хүргэж байна.

Усны тухай хуулиас: 26 дугаар зүйл.

Ус ашиглах зориулалт, төрөл



Ус хэрэглэгч; Үүнд иргэд мал аж ахуй болон унд ахуйд хэрэглэхийг ойлгоно .



Ус ашиглагч; Үүнд иргэн болон ААН нь үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглахыг ойлгоно .

Усны тухай хуулиас: 27 дугаар зүйлээс: Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл

27.1. Цооног ерөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах зөвшөөрлийг ус хэрэглээний тоо хэмжээ, чанарыг үндэслэн **Аймаг, нийслэлийн байгаль орчны газар** нь хуулийн дагуу худаг гаргах зөвшөөрлийг олгоно.




Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйл: Усны тухай хууль зөрчих

- ✓ 1.Хуульд заасны дагуу
- ✓ 1.1. Усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан;
- ✓ 1.2. Цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан;
- ✓ 1.3. Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- ✓ 1.4. Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
- ✓ 1.5. Усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн;
- ✓ 1.6. Ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйл: Усны тухай хууль зөрчих

- 1.Хуульд заасны дагуу
- 1.1. усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан;
- 1.2. цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан;
- 1.3. ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 1.4. ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
- 1.5. усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн;
- 1.6. ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж
Иргэнийг - 150,000 төгрөг, ААН-агийг - 1,500,000 төгрөгөөр торгоно!!!



Иргэн - 150,000 төгрөг, ААН - 1,500,000 төгрөгийн торгуультай!!!

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

- Нийгмийн даатгал нь ТӨР, АЖИЛ ОЛГОГЧ, ИРГЭН-ДААТГУУЛАГЧ-ийн төлсөн шимтгэлээр САН бүрдүүлж, уг сангаас:
- ӨНДӨР НАСЛАХ
- ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДАХ
- ӨВЧЛӨХ
- ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ЧӨЛӨӨ ЭДЛЭХ
- АЖИЛГҮЙ БОЛОХОД ӨӨРТ НЬ
- Даатгуулагч НАС БАРАХАД ТҮҮНИЙ АСРАМЖИНД БАЙСАН ХҮМҮҮСТ
- Хууль тогтоомжинд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох замаар орлогын баталгааг нь хангах эдийн засгийн арга хэмжээ юм.
- Хүний амьдралд тохиолдож болох жам ёсны болон гэнэтийн эрсдлийн үед НИЙГМИЙН ДААТГАЛ ТАНД БОЛОН ТАНАЙ ГЭР БҮЛД учирч болзошгүй санхүүгийн эрсдлийг даван туулахад тусална.

*НИЙГМИЙН ДААТГАЛ ТАНЫ
НАСАН ТУРШИЙН БАТАЛГАА*

Тэтгэврийн даатгал гэж юу вэ?

Тэтгэврийн даатгал нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар сэргээгдэх хүртэл, нас барахад түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд/ 0-19 насны хүүхэд/-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор сар бүр тэтгэвэр хэлбэрээр олгох мөнгөн хөрөнгө юм.

Өндөр насны тэтгэвэр авах эрх

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн байх
- Эрэгтэй 60 нас, Эмэгтэй 55 нас хүрсэн байх
- 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмэгтэй даатгуулагч 50 нас хүрсэн байх
- Нийтдээ 10-аас 20 хүртэл жил шимтгэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрхтэй.

Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох эрх

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн байх
 - Тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн байх
 - Хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар алдсан байх
- Нийтдээ 3-аас доошгүй жил шимтгэл шимтгэл төлсөн бол тэтгэврээ хувь тэнцүүлэн авах эрхтэй.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн байх
- Эсхүл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь шимтгэл төлсөн байх
- Нийтдээ 5-аас доошгүй жил, үүнээс 1 жилд нь тасралтгүй төлсөн даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлж олгоно.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

- Нийгмийн даатгалын дэвтэр
- Хөдөлмөрийн дэвтэр
- Ажил хийж байгаа бол ажлаас гарсан тушаал/ эх хувиараа байх/
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах/лавлагаа/
- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэхний хуулбар
- 1% зураг 3x4 хэмжээтэй
- Багийн Засаг даргын тодорхойлолт
- Малчнаар тэтгэвэр тогтоолгох бол малын “А” данс
- Эмэгтэй даатгуулагч гэр бүлийн баталгааны хуулбар

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материал

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох материал дээр
- Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн төрсний гэрчилгээ
- Гэрлэлтийн баталгаа
- Нас барсны гэрчилгээ

ТД-ийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материал

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох материал дээр
- ЭХМК-ын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон акт

Тэтгэмжийн даатгал гэж юу вэ?

Даатгуулагчийг хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд тус даатгалын сангаас тэтгэмж

хэлбэрээр нэг удаа олгох мөнгө юм.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх

- Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сар шимтгэл төлсөн байх
- Даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг ажлын 66 өдрөөс жилд удаа дараа өвдсөн бол ажлын 132 өдрөөс илүүгүй хугацаанд тооцон сүүлийн 3 сарын дундаж хөдөлмөрийн хөлснөөс тооцож олгоно.

Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авах эрх

- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн байх
- Даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 4 сарын хугацаанд ажлын өдрөөр тооцож олгоно.

Оршуулгын тэтгэмж авах эрх

- Ердийн өвчин ахуйн ослын улмаас нас барсан даатгуулагч нийтдээ 36 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлсөн байх
- Тэтгэвэр авагч нас барвал ар гэрт оршуулгын тэтгэмж олгоно.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал гэж юу вэ?

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ гэдэг даатгуулагч ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх үед, ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед, ажилдаа ирэх, буцах замд осолд өртсөн, богино хугацаанд цацраг идэвхт буюу химийн бодисын нөлөөгөөр хордож хурц хордлогод орсон эрсдэл юм.

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН гэдэг нь

хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг хэлнэ.

Эрүүл мэндийн даатгал

- Малчид,хувиараа хөдөлмөр эрхлэгчид,оюутан сурагчид сард 4200 төг,жилд 56700 төгрөгийн хураамж төлнө. Хураамжийг Төрийн банкны 220900097708 тоот дансанд тушаана.
- Жилд 2000000 төгрөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, төлбөрийг авах эрхтэй.
- Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэн-даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж,үйлчилгээний зардлын төлбөр нь тухайн жилийн дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч-гишүүний зөвшөөрснөөр түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэх эрхтэй.
- 2019 оны төлөх шимтгэл сард 3200₮ жилд 38400₮
- 2020 оны төлөх шимтгэл сард 4200₮ жилд 50400₮
- 2021 оны төлөх шимтгэл сард 4200₮ жилд 50400₮
- 2022 оны төлөх шимтгэл сард 4200₮ жилд 50400₮

Сайн дурын даатгал

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Малчин
- Газар тариалан эрхлэгч
- Бичил уурхай эрхлэгч
- Чөлөөт уран бүтээлч
- Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн
- Гадаад улсад ажиллаж амьдарч буй иргэн
- Оюутан сурагч нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдаж болно.
- Сайн дурын даатгуулагч эрүүл мэнд,нийгмийн даатгалын

байцаагчтай гэрээ байгуулж тохирсон хугацаанд өөрийн мэдүүлсэн сарын хөдөлмөрийн хөлс орлогоос тооцон шимтгэл төлнө.

- Сард $420000 \times 13.5\% = 56700$ төг/хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс/
- Жилд $56700 \times 12 = 680400$ төг төлнө.
- Сард $4200000 \times 13.5\% = 567000$ төг /хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ/
- Жилд $567000 \times 12 = 6804000$ төг төлнө
- НДШ-ийг Төрийн банкны 220900097694 тоот дансанд төлнө.
- Гэрээ сунгах хүсэлтээ гэрээний хугацаа дуусахаас өмнө НД-ын байцаагчид гаргана.

Малчны тэтгэвэр

- Улсад 20 жил түүнээс дээш жил ажилласан байх
- Үүнээс эрэгтэй малчин 15 жил, эмэгтэй малчин 12 жил 6 сар малчнаар ажилласан малын "А" данстай байх
- Эрэгтэй 55 нас, эмэгтэй 50 нас хүрсэн байх гэсэн ерөнхий 3 болзол хангаж малчнаар тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.

0-3 Хүртэл настай хүүхдээ асарч байгаа эхчүүдийн даатгал

0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа байгаа эхчүүд сайн дурын даатгалын гэрээний хугацаанд сард төлвөл зохих шимтгэлийн 50%-ийг өөрөө төлсөн тохиолдолд 50%ийг тэтгэмжийн даатгалын сан, улсын төсвөөс төлнө.

$420000 \times 12,5\% = 52500$ ₮ Сард даатгуулагч эх 26250 төг төлнө.

Бүрдүүлэх материал

- ИҮ-ний хуулбар
- Хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар


Анхаарах асуудал:

- ❖ **2020, 2021** онуудад малчин ХХЭ-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хуулийн дагуу хамрагдсан малчид үргэлжлүүлээд нийгмийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн насанд хүртлээ тасралтгүй төлөөрэй. Төлөхгүй байвал малчнаар ажилласан жил чинь хүрэхгүй байх магадлалтай шүү.
- ❖ Сайн дурын даатгалын гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа хугацаа хоцроож даатгалаа төлсөн тохиолдолд төлөөгүй сарыг алгасч тухайн алгассан сар тасарсанд тооцогдож даатгал төлсөн сараас эхлэн мэдээллийн цахим санд бүртгэгддэг тул гэрээ дуусах хугацаагаа асууж байгаарай.

*НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН АМСАР ДҮҮРЭН БЯЛХАЖ
ДААТГУУЛАГЧДЫН АМЬДРАЛ ЭЛБЭГ ХАНГАЛУУН БАЙХ
БОЛТУГАЙ.*

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН УЛСЫН БҮРТГЭЛ

Харьяалал харгалзах 5 бүртгэл



Харьяалал харгалзахгүй 10 бүртгэл



ИРГЭН ТА

2006 ОН
ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ
ШИНЭЭР АВАХ

1997 ОН
25 НАСНЫ
СУНГАЛТ

1977 ОН
45 НАСНЫ
СУНГАЛТ

ХУГААЦААНДАА ИРГЭНИЙ
ҮНЭМЛЭХЭЭ ЗАХИАЛЖ,
СУНГАЛТАА ХИЙЛГЭНЭ ТУ

ДУНДГОВЬ АЙМАГ

**Та бүхэнд иргэний үнэмлэхний
төлбөр хураамжийг танилцуулъя**

- Иргэний үнэмлэх шинээр буюу 16, 25, 45 насны сунгалт хийлгэж байгаа тохиолдолд
Иргэний үнэмлэхний - 15,000₮
Тэмдэгтийн хураамж - 3,300₮
Нийт - 18,300₮
- Иргэний үнэмлэх дүр төрхийн өөрчлөлт, гэмтээсэн, хаягийн өөрчлөлт хийлгэж байгаа тохиолдолд
Иргэний үнэмлэхний - 30,000₮
Тэмдэгтийн хураамж - 3,300₮
Нийт - 33,300₮
- Иргэний үнэмлэх хаяж үргэлүүлсэн бол
Иргэний үнэмлэхний - 30,000₮
Тэмдэгтийн хураамж - 3,300₮
Торгууль - 30,000₮
Нийт - 63,300₮

16, 25, 45 насны сунгалтын хугацаа хэтэрсэн тохиолдолд торгууль 20,000₮ болсныг АНХААРНА УУ!!!

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Тоон гарын үсгийн хууль 2022 оны 05 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэллээ



Тоон гарын үсэг


Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар эцэслэн баталсан бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

Хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд таван жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан.

Тоон гарын үсгийг Улсын бүртгэлийн байгууллагаар дамжуулан хүсэлт гаргасан иргэн бүрд олгоно.

WWW.BURTGEL.GOV.MN 1800-1890

Та өөрийн иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглах боломжтой боллоо



Гэрчилгээ олгох

Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт харьяалал харгалзахгүй хандаж тоон гарын үсэг авах хүсэлтийг гаргана.

- Иргэний үнэмлэхийн хамт биечлэн ирнэ.
- Бичгээр гаргана.

Иргэн тоон гарын үсэг авах хүсэлтийг Улсын бүртгэлийн байгууллагын киоск машинд хандан цахим хэлбэрээр гаргаж болно.

Гэрчилгээ системээс үүсгэгдэж, тоон гарын үсгийн ПИН код, ПУК код, зөвлөмжийг иргэний цахим шуудан, гар утсанд илгээнэ.

Иргэний тоон гарын үсэг авах хүсэлтийг аймаг, нийслэлийн Улсын бүртгэл хүсэлтийг хүлээн авч харьяалал харгалзахгүй олгоно. Иргэн та өөрийн биеэр хүсэлт гаргах бөгөөд таны Биеийн давхацахгүй өгөгдөлийн гарын хурууны хээгээр таньж баталгаажуулж тоон гарын үсэг үүсгэн Иргэний үнэмлэхний санах ойд байршуулна.

ТООН ГАРЫН ҮСЭГ

**ТООН ГАРЫН ҮСГИЙГ ХААНА,
ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?**

- Бүх төрлийн төрийн цахим үйлчилгээ
- Гэрээ, хэлцэл байгуулах
- Банк, санхүү, төлбөр тооцоо
- Даатгал, эрүүл мэндийн үйлчилгээ
- Өргөдөл, хүсэлт, зөвшөөрөл, албан тоот
- Бусад бүх төрлийн цахим сервисүүд

Тоон гарын үсэг нь дэлхийн олон оронд хүлээн зөвшөөрөгдсөн, хэрэглэхэд хялбар бөгөөд таны аюулгүй байдлыг бүрэн хангана.

WWW.BURTGEL.GOV.MN 1800-1890

Иргэн та Улсын бүртгэлийн Ерөнхий газраас олгосон тоон гарын үсгээр төрийн болон бусад байгууллагаас цахим үйлчилгээ авах, гэрээ хэлэлцээр байгуулах, санхүүгийн төлбөр тооцоо хийхэд ашиглан өөрийн цаг хугацаа зардлаа хэмнэн цахим орчинд өөрийгөө таниулах боломжтой.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Цахим хэлбэрээр халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ хэрхэн гаргах вэ?

- Иргэн та www.ehalamj.mn сайдат зааврын дагуу бүртгүүлж, нэвтрэх эрхтэй болсноор цахим хэлбэрээр халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргах боломжтой.

Цахим хэлбэрээр хүсэлт гаргахын тулд ямар нөхцөл шаардлага хангах ёстой вэ?

- Иргэн та арилжааны банкинд өөрийн нэр дээр заавал данс нээлгэсэн байх шаардлагатай. Учир нь та дансны дугаараа бүртгүүлснээр халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө шууд өөрийн дансанд шилжүүлэн авах боломж бүрдэнэ.
- Хэрэв та жирэмсэн эх, цалинтай ээж, ихэр хүүхдийн тэтгэмж авах гэж байгаа бол харьяа өрхийн эмнэлэгт хандан эмчийн үзлэгт хамрагдсан байх шаардлагатай.

Цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийн шийдвэрлэлтийн хяналт боломжтой юу?

- Иргэн та www.ehalamj.mn-д өөрийн нэвтрэх эрхээр орсноор нийгмийн халамжийн байгууллага. Таны хүсэлтийг хэрхэн шийдвэрлэж байгаа үйл явцыг системээс хянах бүрэн боломжтой.
- Мөн таны гар утас болон цахим шууданд шийдвэрлэлтийн явцын талаар тухай бүр мэдэгдэл ирнэ.

Ямар тохиолдолд халамжийн тэтгэмжийн мөнгө хугацаандаа орохгүй байх вэ?

- Таны хүсэлтийг нийгмийн халамжийн байгууллага судлан үзээд хууль, журамд заасан нөхцөлийг хангасан бол тэтгэмжийн мөнгийг сар бүрийн 15, 25-ны өдөр таны цахим системд бүртгүүлсэн дансанд шилжүүлнэ. Хэрэв таны дансны дугаарын мэдээлэл зөрүүтэй бол тухайн

